



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/303

Сүхбаатар сум

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "ж", 29.1.6 "а", Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 зүйлийн заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замаас ирүүлсэн гомдлыг судлан, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Б.Саруултөгс – Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын дарга


Гишүүд

Л.Баярсүрэн - Хууль, эрх зүйн хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

М.Эрдэнэтогтох – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Өргөдөлд дурдсан асуудлаар газар дээр нь шалгаж дүгнэлтээ 2020 оны 11 дүгээр сарын 06-ны дотор гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ